

УДК 24-9

DOI: 10.22162/2500-1523-2020-3-414-429



IX Богд Жавзандамбын халимаг дахь үйл хэрэг (= О деятельности IX Богдо-гэгэна Джебцун-дамба-хутухты среди калмыков)

*Наранжаргал Норовсамбуу*¹

¹ Центр по изучению языка и культуры ойратов «Тод номын гэрэл»
(8, район Сухбаатар, ул. Бага тойруу, 210646 Улан-Батор, Монголия)
научный сотрудник

 0000-0001-5788-4618. E-mail: naranjargal_85@yahoo.com

© КалмНЦ РАН, 2020

© Наранжаргал Н., 2020

Аннотация. *Введение.* В странах, где буддизм получил распространение, особо известна деятельность высоких буддийских учителей, благодаря которым учение Будды получило дальнейшее развитие. Среди них наиболее известными являются Далай-лама и Панчен-лама. В Монголии со времени широкого распространения буддизма самым известным буддийским ламой является Богдо-гэгэн. К настоящему времени насчитывается девять перерождений Богдо-гэгэна, который внес неоценимый вклад в развитие буддизма в Монголии. *Цель* данной статьи — проанализировать события истории визитов IX Богдо-гэгэна Джебцун-дамба-хутухты к калмыкам Поволжья, которые являются частью монгольского мира, а также дарованного им учения. *Результаты.* В статье освещаются основные события биографии Богдо-гэгэна. Приводятся сведения о шести визитах IX Богдо-гэгэна в Калмыкию в конце 1990-х — начале 2000-х гг. Отмечается, что в организации визитов в Калмыкию IX Богдо-гэгэна большая работа была проведена руководством Республики Калмыкия и Шаджин-ламой Калмыкии Тэло Тулку Ринпоче. Визиты IX Богдо-гэгэна в Калмыкию оказали большое влияние на развитие буддизма в республике.

Ключевые слова: буддизм, IX Богдо-гэгэн Джебцун-дамба-хутухта, биография, монголы, калмыки

Для цитирования: Наранжаргал Н. IX Богд Жавзандамбын халимаг дахь үйл хэрэг (= О деятельности IX Богдо-гэгэна Джебцун-дамба-хутухты среди калмыков) // Монголоведение. 2020. Т. 12. № 3. С. 414–429. (На монг.). DOI: 10.22162/2500-1523-2020-3-414-429

UDC 24-9

DOI: 10.22162/2500-1523-2020-3-414-429

9th Jebtsundamba Khutuktu and the Kalmyks

Naranjargal N.¹

¹ “Tod Nomyn Gerel” Center for the Research of Oirat Language and Culture
(8, Sukhbaatar dist., Baga Toiru St., Ulaanbaatar, Mongolia)

 0000-0001-5788-4618. E-mail: naranjargal_85@yahoo.com

© KalmSC RAS, 2020

© Naranjargal N., 2020

Abstract. Introduction. Traditional Buddhist communities are well aware of prominent Buddhist scholars to have further disseminated and developed the Buddha’s Teaching. The most famous are Dalai and Panchen Lamas. Since the beginnings of Buddhism’s prevalence in Mongolia, it is Bogd Gegeen who is revered most of all nationwide. To date, there have been nine reincarnations of Bogd Gegeen that immensely contributed to the development of Buddhism in the country. **Goals.** The paper seeks to analyze visits of the 9th Bogd Gegeen Jebtsundamba Khutuktu to the Volga Kalmyks (as members of the Mongolian world) and his delivered teachings. **Results.** The article highlights key points of the Bogd Gegeen’s biography, narrates about his six visits to Kalmykia in the late 1900s and early 2000s. Special focus is laid on that most significant efforts to arrange the visits were undertaken by Kalmykia’s government executives and Shajin Lama Telo Tulku Rinpoche. Those events proved fruitful enough and facilitated further strengthening of Buddhism in the region.

Keywords: Buddhism, 9th Bogd Gegeen Jebtsundamba Khutuktu, biography, Mongols, Kalmyks

For citation: Naranjargal N. 9th Jebtsundamba Khutuktu and the Kalmyks. *Mongolian Studies (Elista)*. 2020. Vol. 12. No. 3. Pp. 414–429. (In Mong.). DOI: 10.22162/2500-1523-2020-3-414-429

Оршил. IX Богдын намтар

Есдүгээр богд Жавзандамба хутагт Жамбалнамдолчойжиганцан нь Төвдийн Үй мужийн Лхаданбрүл (Лхас хот) хийдийн хойд талд Томсигийн даваанд эцэг Рало (Ра лозваа) овгийн Лувсанжамбал, эх Янжинлхам нарынхаа хүү нь болж 16-р жарны усан бичин жил буюу 1932 онд төржээ. Түүнийг эхийн хэвлийд байх үеэс нь шашны томоохон зүтгэлтнүүд мэдэрч, хувь тойргийнх нь тухай өгүүлж байв. Тухайлбал:

— Ердүгээр Гандан ширээт дрэхор Жамбачойдаг ринбүчи «бусдаас маш ялгаатай их дээдэс байна» хэмээн айлдаж, Содномдаржай нэр өгсөн.

— Богд Павонхава Дэчиннимбу түүнд Соднамданзандаржай нэр өгсөн.

— Хараг ёнзин ринбүчи «Жамъян цоржийн хойт дүр мөн байна» гэж тодруулсан

— Найчинчойжил «жинхэнэ Жамъяаннамхайноров, Жамъяан цоржийн хувилгаан эндүүрэлгүй мөн» хэмээн баталсан байна.

Түүнийг 4 нас хүрэхэд нь XIII Далай ламын тамга барьж байсан Радэн ринбүчи Түвдэнжамбал-Иш болон Найчун Чойжин нар Халхын 8-р богд Жавзандамбын хойд дүр болохыг тодруулсан ч Монгол, Төвдийн харилцаа зогсонги, сул аль аль нь хүчин мөхөс буурай байснаас олон түмэнд танигдаж чадаагүй юм. Тэрээр Халхын анхдугаар богд Занабазарын ес дэх, Жамъяанцоржийн арван дөрөв дэх, бандида Барбизовугийн хорин гурав дахь, бодисадва Дов Тамэдын хорин найм дахь төрөл нь аж.

Тэрээр 8 насандаа Радэн рибүчи Түвдэнжанбал-Ишээс гэгцлийн сахил хүртэн Жамбалнамдолчойжижанцан хэмээх нэртэй болж Брайбүн, Гоман дацангуудад шавилан гэвш Агванчойдан, Буриад дулба хамба Түвдэнням, Халх гэвш Дашжамц нарт шавь орсон байна. 1952 оноос Дагдан хийдэд заларч хийдийн барилга байгууламж, хурал номын дэг жаягийг сэргээх зэрэгт ихээхэн зүтгэсэн байна. Улмаар 1959 онд цаг төрийн байдал ороо бусгаа болох үед Төвдөөс дүрвэн гарч Энэтхэгт суурьшсан байна.

1990 оны үеэс Жавзандамба хутагтын хойд дүрийг тодруулах асуудал Далай лам болон монголын бурхны шашны зарим томоохон төлөөлөгчид, Төвөдийн удирдах албан тушаалтнуудын дунд яригдах болжээ. Төр засгийн өндөр албан тушаалтнууд ч 9-р богдыг тодруулах асуудалд нааштай хандаж байсан бололтой. Ингэснээр Далай лам *«Халх Жавзандамбын 9-р дүрд Жамбалнамдолчой-жинжанцанг урьд өмнөх дүрүүдийн тодруулдаг журмын дагуу үнэхээр мөн гэж үзээд шашин амьтанд үлэмж сэтгэл, тааллыг машид төрүүлсэн, судар тарнийн ёсонд сонсож, санахыг нарийн судалж мэргэшсэн энэхүү лам нь Халхын Жавзандамбын 9-р дүр мөн байна. Нас сүүдэр өнөд бат оршиж эртний тавьсан сайн ерөөлөөр холбогдсон их Монгол оронд шашин амьтны тус амгалан арвижуулан зохион үйлс нь дээшлэн дэлгэрэхийн ерөөл дэвшүүлье»* гэсэн 1991.9.20 өдрийн захидал, өмнө нь түүнийг тодруулж байсан баримт зэргийг Халх богдод өргөснөөр 1992.12.13-нд Төвөдийн засгийн газрын шашин соёлын яамнаас түүнийг сэнтийд нь залсан байна [[Айлдвар сургаал 2009: 10](#)].

Тэрээр энэ үеэс эхлэн АНУ, Канад, Сингапур, Тайван, Швейцарь, Унгар, Швед, Австрали, Хятад, Тайван, Монгол зэрэг гадаад орны сүсэгтэн олондоо сургаал номлолоо айлдах болжээ.

IX Богд нь 1999 онд анх заларсан бөгөөд түүнийг 1999.8.4-ний өдөр монголын нөлөө бүхий 17 хийдийн тэргүүнүүд урьдын богдуудын ээлж дараалан заларч байсан монголын анхны хийд болох Эрдэнэ зуу хийдэд нууц байдлаар ширээнд нь залж, «Аврал итгэлт Жавзандамба хутагт умар зүгийн шашны эзэн» гэсэн цол өргөсөн юм.

Түүний хүсэлтийг үндэслэн 2010 онд Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган Монгол улсын харьяат болгосон бөгөөд 2011 онд Гандантэгчэнлин хийдэд IX Богд Жамбалнамдолчойжижанцан хутагтыг Монголын бурхны шашны тэргүүнээр дахин өргөмжилж, ширээнд залах ёслол Гандантэгчэнлин хийдэд болов. 2012 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж зарлиг буулган, Монголын бурхны шашны тэргүүн хэмээн батламжлав. 2012 оны 3 дугаар сарын 1-ны өдөр буюу Цагаан Сарын шинийн наймны өдөр Монголын бурхны шашны тэргүүн IX Богд Жамбалнамдолчойжижанцан хутагт наян нэгэн насны сүүдэртэйдээ Улаанбаатар хотод Гандантэгчэнлин хийдэд таалал барив.

IX Богд Жавзандамбын Халимаг дахь үйл хэрэг

IX Богд Жавзандамба нь 1997 онд анх ОХУ-д заларч сүсэгтэн олонтой уулзсанаасаа хойш Халимагт 1997, 1998, 1999, 2000, 2002, 2003, 2005, 2009 онуудад заларсан тухай аман болон бүрэн бус мэдээ байдаг бол Халимагийн бурхны шашны тэргүүн XII Дилов хутагт Тэло Тулку ринбүүчи нэгэнтээ *«... халимагт богд 4 удаа заларч ном айлдсан»*¹ хэмээсэн байдаг. Миний цу-

¹ Дилов хутагтын хойт дүр Тэло Тулку ринбүүчитай Улаанбаатар хотод 2014.4.20-ний өдөр хийсэн ярилцлага [[Батсайхан 2015: 339–343](#)].

глуулсан баримт материалаас үзэхэд IX Богд халимагт 6 удаа заларсан байна. Эдгээрийг авч үзвэл:

Анх удаа халимагт очсон нь: IX богд Жавзандамбын анх Халимагт очсон он цаг нь тодорхой бус байна. Баримтаас үзвэл тэрээр 1997 онд 6–7 дугаар сард ОХУ-ын Буриадад очиж сүсэгтэн олонд ном айлдаад [История буддизма 2011: 278] буцсан байна. Харин тэндээс Халимагт очсон тухай албан ёсны баримт олдохгүй байна. Харин 2011 онд Халимагийн хүмүүнлэгийн судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргаж хэвлүүлсэн «ОХУ болон ЗСБНХУ-ын буддын шашны түүх» хэмээх бүтээлд «IX Богд гэгээн 1998 оны 9 сард Халимагт заларсан» [История буддизма 2011: 279] гэсэн нь IX Богдын Халимагт заларсантай холбогдох анхны мэдээ юм. Эндээс түүнийг 1998 онд анх Халимагт заларсан гэж үзэж байна. Дээрх бүтээл болон бусад ном зохиолд IX Богдыг Халимагт ямар зорилгоор ирж, юу хийсэн, хэдий хугацаагаар байсан тухай баримт мэдээ байхгүй бөгөөд энэ талаарх архивын баримт ч надад олдсонгүй. Энэ байдлыг IX Богд Халимагт анх удаа очсон, түүнийг сүсэгтэн олон төдийлөн таньж мэдээгүй байсан зэрэгтэй холбон үзэж болох юм.

Хоёр дахь айлчлал: IX Богд 1999 оны 6 дугаар сард [Батсайхан 2015: 81] дахин ОХУ-д дахин морилсон. IX Богд нь энэ хүртэлх хугацаанд улс төр болон бусад шалтгааны улмаас Монголд очиж чаддаггүй байлаа. Монгол улсад морилон сүсэгтэн олонтойгоо уулзах хүсэж явдаг түүнд энэ удаад ОХУ дахь Монгол улсын элчин сайдын яамнаас Монгол улсад орох жуулчны виз авсан² байна. Урьд төрөл монголчуудын дунд бурхан мэт тахигдаж, Монгол улсын хаан байсан түүний хувьд жирийн нэгэн жуулчны хувиар Монголд улсад хөл тавих нь үл зохицох зүйл гэж тэрээр үзэж, ядахдаа төрийн урилгаар очихыг хүсэж байсан бололтой. Энэ ч үүднээс байдлыг харзнахаар Халимаг руу явснаар [Батсайхан 2015: 274–291] Халимагт 2 дахь удаагаа очжээ.

Түүний энэ удаагийн айлчлал 1999.6.29-7.8-ны хооронд үргэлжилжээ [Хальмг үнн 1999: 1]. Энэ удаагийнх нь айлчлалын талаар баримт материал мөн цөөн байгаа ч тэдгээрийг халимагийн зарим сүсэгтний дурсамж, аман баримт зэрэгтэй холбон тодруулж болмоор байна. «IX Богд гэгээн 1999 онд халимагт морилоход нь түүнийг халимагийн ард түмэн сайн таньдаггүй байсан тул айлын гэрт байсан ...».(Корнеев Г.Б. Богд гэгээн надад эрх бэлэглэсэн. Дурсамж яриа) ба энэхүү айл нь бурхны шашинд элэгтэй дунд сургуулийн багш Любовь Сергеевна Буринова [Его Преосвященство ...] гэх сүсэгтнийх байжээ. Тэрээр энэ удаагийн айлчлалынхаа үеэр Халимагийн нийт сүсэгтнүүд дээ Ямандаг бурхны авшиг хүртэж, Элиста хотоос гадна Черноземельск районы Комсомольск хотод очсон байна.

Энэхүү мэдээ баримтыг дахин нягтлан үзэх шаардлагатай бөгөөд Халимагт 2 дахь удаагаа ирж байгаа, мөн сүсэгтэн олонд Ямандаг бурхны авшиг хүртээх гэх мэтээр томоохон номын үйл хийж байсан тэрээр жирийн нэг сүсэгтний гэрт байрлаж байсан гэхээр төдийлөн итгэл төрөхгүй байгаа ч түүнтэй уулзаж, сургаал номлолд нь оролцож байсан сүсэгтний дурсамжийг анхааран үзэхгүй орхиж болохгүй байна.

IX Богдын ийнхүү Халимагт хоёр дахь удаагаа морилох үед Халимагт монголын консулын төлөөлөгчөөр ажиллаж байсан Н. Бүдбазар Монгол улсын Ерөнхийлөгч байсан Н. Багабандитай танил байдлаа ашиглан Монгол улсад

² Богдын хүү Чоймпол-Ёндонтой хийсэн ярилцлага [Батсайхан 2015: 274–291].

төрийн шугамаар урьсан байна [Батсайхан 2015: 93]. Ийнхүү Халимаг дахь монголын консулын төлөөлөгчийн тусламжтайгаар IX Богд Монгол нутагтаа анх удаа морилсон байна. Харамсалтай нь түүнийг монгол улсад төрийн шугамаар урьсан Бүдбазарыг *улс төрийн хэрэг өдүүлсэн хэмээн хавчин, шалгаж байгаа*³ улмаар IX Богдод «...*виз өгч монголд оруулсан*»⁴ гэдэг хэргээр албан тушаалаас нь огцруулсан байна. IX Богд 1999.7.13-9.17 хүртэл Монголд морилоод буцаж Буриад, Москвагаар дайран Халимагт дахин очоод Энэтхэг руу буцсан⁵ гэж IX Богдын орчуулагч Тэнгон лам ярилцлага дурдсан ч түүнийг буцаж Халимагт очсон тухай баримт алга байна.



Зураг 1. IX Богдыг монголд угтан авч буй нь. 1999 он [Батсайхан 2015: 714]
Зүүн гар талаас: Баянцагаан, Д.Баасан, Нацагдорж, Гончигсүрэн лам, консул
Бүдбазар нар

[Fig. 1. Welcoming His Holiness the 9th Bogd Gegeen to Mongolia. 1999 [Батсайхан 2015: 714]. From left to right: Bayantsagaan, D. Baasan, Ven. Natsagdorzh, Ven. Gonchigsuren, Consul Bodbazar]

Гурав дахь айлчлал: IX Богдыг 2000, 2002 онуудад Москва болон Халимагт заларсан хэмээн судлаач О. Батсайхан бүтээлдээ дурдсан ч ямар хэргээр очсон, очоод юу хийсэн хэдий хугацаанд байсан тухай өгүүлээгүй байна [Батсайхан 2015: 82]. 2002 оны тухайд Октябрьский районы Большой Царын тосгоны «Храм Великой Победы» (халимагаар Алдр Диилврин сүм, архитектор Сангаджиев Ю.И.) сүмийн нээлт 2002 оны 6 сард болсон бөгөөд уг сүмийн нээлтэд хүрэлцэн ирсэн IX Богд тус сүмд Агуу ялалтын сүм гэх нэрийг хайрласнаас үзвэл 2002 оны зун халимагт дахин заларсан байна. Харин 2000 онд очсон талаар ямар нэгэн баримт материал олдохгүй байна.

³ Сүсэгтний холбооны тэргүүнээр ажиллаж байсан лам С. Баянцагаан: Богд бол монголын бурхны шашны жинхэнэ тэргүүн. 2014.4.16. Лаиран дацангийн тэргүүнээр ажиллаж байхад нь дацанд нь хийсэн ярилцлага [Батсайхан 2015: 407–410].

⁴ Богдын дэргэдийн шавь Түвдэндулам: Богд маань үнэхээр бодьсатва байсан [Батсайхан 2015: 454–465].

⁵ Богдын орчуулагч лам Тэнгон: Их монгол улсын газар нутгийн хамааралтай хүмүүстэй Богд гэжээнтэн язгуурын холбоотой байсан шиг санагддаг. 2015.2.3 өдрийн ярилцлага [Батсайхан 2015: 551–552].



Зураг 2. IX Богд Халимагт айлчилж буй нь. 2002 он [Далай-лама и Калмыкия: 35]⁶
[Fig. 2. 9th Bogd Gegeen in Kalmykia. 2002]



Зураг 3. IX Богд Халимагийн сүсэгтнүүдэд ном айлдаж буй нь. Сахиусан сүм. 2002 он.
[Далай-лама и Калмыкия: 24]
[Fig. 3. 9th Bogd Gegeen preaching a sermon in Kalmykia. Säküsн Sүme Temple. 2002]

⁶ «Далай лам ба Халимаг» (35 х.) товхимлоос авсан зураг (хэвлэлийн газар он, газрыг нь заагаагүйгээр хэвлэгдсэн) (=Фото из буклета «Далай-лама и Калмыкия» (с.35), выпущенного в г.Элисте без указания года и издательства. — Ред.)



Зураг 4. IX Богд Халимагийн сүсэгтнүүдэд ном айлдаж буй нь. Сахиусан сүм 2002он
[Далай-лама и Калмыкия: 37]

[Fig. 4. 9th Bogd Gegeen preaching a sermon in Kalmykia. Säküsñ Süme Temple. 2002]



Зураг 5. IX Богд Халимагийн сүмд. 2002 он [Батсайхан 2015: 750].

[Fig. 5. 9th Bogd Gegeen in a Kalmyk Buddhist temple. 2002]

]



Зураг 6. IX Богдын нэрийг нь хайрласан Агуу ялалтын сүм
[Fig. 6. Temple of the Great Victory named by the 9th Bogd Gegeen]

Дөрөв дэх айлчлал: 2003 онд дөрөв дэх удаагаа Халимагт айлчлах үеэрээ [Хальмг үнн 2003: 2] Дүйнхэрийн ван нэрээр сүсэгтэн олонд алдаршсан Цагийн хүрдэн эрх авшиг хэмээх 14 хоног айлддаг номыг Халимагийн ард түмэнд зориулан бүтнээр нь айлдсан нь бурхны шашинд ховорхон тохиолдох үйл явдал болсон юм [История буддизма 2011: 96].



Зураг 7. IX Богд Халимагт Цагийн хүрдний ван айлдаж буй нь. 2003 он
[Батсайхан 2015: 748].
[Fig. 7. 9th Bogd Gegeen bestowing the Kalachakra teachings in Kalmykia. 2003]



Зураг 8. IX Богд Халимагт хотол мандал бүтээж буй нь. 2003 он
[Батсайхан 2015: 746]

[Fig. 8. 9th Bogd Gegeen creating a mandala in Kalmykia. 2003]



Зураг 9. IX Богд Халимагт цагийн хурдний ван айлдаж байгаа нь. 2003 он
[Батсайхан 2015: 749].

[Fig. 9. 9th Bogd Gegeen bestowing the Kalachakra teachings in Kalmykia. 2003]



Зураг 10. IX Богд Халимагт цагийн хүрдний ван айлдах үед Дилов хутагт мандал, гурван шүтээн өргөж буй нь. 2003 он [Батсайхан 2015: 749].

[Fig. 10. Telo Tulku Rinpoche offering a mandala to the 9th Bogd Gegeen. 2003]



Зураг 11. Зүүн гар талаас: IX Богд, Халимагийн ерөнхийлөгч, хутагтын орчуулагч, Дилов хутагт, Арын эгнээнд Ёндонжамц нар Халимагт: 2003 он [Батсайхан 2015: 749].

[Fig. 11. 9th Bogd Gegeen in Kalmykia. 2003. From left to right: President of Kalmykia, translator, Telo Tulku Rinpoche. In the rear row — Ven. Yondonjamtsol]

Халимаг дахь 5 дахь айлчлал: Тэрээр халимагт 2005 онд 8 дугаар сарын 5–11 хооронд 5 дахь удаагаа айлчилсан байна [Программа визита 2005]. Энэ үеэрээ тэрээр Халимагийн сүсэгтэн олондоо зориулан Хаянхярваа бурхны авшиг айлдаж сүсэгтэн олныг ихээр хүлээн авч уулзсан байна [О приезде 2005]. Энэ үед Геннадий Корнеевын тэргүүлдэг байсан «Буддийское молодежное сообщество» буюу «Бурхны шашинт залуучуудын нийгэмлэг»-ээс IX Богдод 100 долларын үнэ бүхий монгол дээл бэлэглэсэн бөгөөд Богд гэгээн тэдэнд эрх бэлэглэсэн байдаг ...» (Корнеев Г.Б. Богд гэгээн надад эрх бэлэглэсэн. Дурсамж яриа).



Зураг 12. IX Богд-гэгээн айлчлалын үеэр халимагуудтай хамт
[Fig. 12. 9th Bogd Gegeen with Kalmyk believers]

Халимаг дахь 6 дахь айлчлал: IX Богд нь 2007 оны 11 дүгээрийн 5–11-нд Халимагийн Шажин лам Тэло Тулку Ринбүүчийн урилгаар Халимагт айлчилсан [В Калмыкии ... 2007]. Тэрээр энэ үеэрээ Халимагийн сүсэгтэн олондоо зориулан Манал бурхны ерөөл, 37 бодьсадын сургааль, 35 бурхны наминчлахуй, Бодьсадын санваар, нас уртасгах ерөөл зэрэг ном айлдаад, сэтгүүлчид, төр засгийн удирдагчид, оюутан, залуучуудтай уулзаад буцсан байна [Визит 2007].

Халимаг ард түмэн ба IX Богдод холбогдох бусад харилцаа

IX Богд болон Халимагийн ард түмний хоорондын харилцаа нь дээрх IX Богдын Халимагт хийсэн 6 удаагийн айлчлалаар хязгаарлан үзэж болохгүй юм. Энэ харилцаанд IX-р Богдтой шашны хэргээр харилцаж байсан нам төрийн албан хаагчид, бурхны шашны тэргүүн, шашны байгууллага, Төвд болон Энэтхэгт бурхны номд суралцаж буй халимаг хуврагууд болон IX-р Богдод мөргөхөөр очсон сүсэгтэн олны харилцаа онцгой байр эзэлнэ.

Тухайлбал IX-р Богдтой нягт харилцаа холбоотой байсан хүн бол тухайн үед Халимагийн Бүгд Найрамдах Улсын тэргүүнээр ажиллаж байсан К.Н. Илюмжинов юм. Нутаг орондоо бурхны шашныг дэлгэрүүлэхэд үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэсэн түүний төр барьж байх үед бурхны шашны гурван өндөрлөгийн нэг болох IX Богд халимагт заларч байсан байна. Энэхүү үйл явдал нь К.Н. Илюмжиновын санал, сүсэг бишрэл, нэр хүнд, идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд болсон нь эргэлзээгүй.

Халимагийн ард түмнээс IX Богд Жавзандамба хутагттай ихээхэн ойр дотно байсан өөр нэгэн хүн бол Халимагийн бурхны шашны тэргүүн Дилов хутагт юм. Тэрээр IX Богдтой «... 1980 онд ... Богдын хойд дүрээр тодроогүй ... Гоман дацанд ном айлдаж байх үед нь анх уулзсан ...» бөгөөд энэ үед түүнийг «... монголын хувилгаан гэдгийг нь мэддэг ч яг хэн гэдгийг нь мэддэггүй байсан...» бөгөөд «...1990 оноос л 9 дүгээр богдын хойт дүр гэдгийг нь мэддэг



Зураг 13. IX Богд Жавзандамба Халимагийн Ерөнхийлөгч
Курсан Илюмжиновын хамт 2005 он [Батсайхан 2015: 746].

[Fig. 13. 9th Bogd Gegeen and Head of Kalmykia K. Ilyumzhinov. 2005]

болсон...»⁶ байна. Улмаар түүнийг 8 дугаар Богдын хойт дүрээр тодорсон үеэс тэдний харилцаа улам ойртсон болох нь 2001 онд IX Богдыг Буриадын Баргужин сүмд айлчлах үеэр «...Тэло хутагт төвд сувилагч эхнэрийнхээ хамт үйлчилж байсан»⁷-аас харагдана. Энэ үед IX Богдыг халимагийн сүсэгтэн олон багагүй мэддэг болсон нь энэ үед түүнд «мөргөхөөр Халимагаас олон сүсэгтэн ирсэн» [Батсайхан 2015: 466–488] байна.

Тэло хутагт IX-р Богдын тухай түүнийг бид «Халх ринбүүчи гэх нь маш буруу...» бөгөөд «...1991 онд Далай багш тодруулаад залж байхад нь ... төвд хүн гэж үзсэн нь ... ичмээр... тэр үед Богдоо залчихсан бол өдийд бурхны шашны үндэс сууриа илүү сайн тавьчихсан байшингаа барьж байх байсан»⁸ хэмээн ярьсан нь манай шашны хөгжлийн тухайд нэгийг бодогдуулах зүйл юм. Үнэндээ IX Богд Халимагт хэдэнтээ айлчилснаас гадна Буриад, Тува зэрэг монгол угсаатнууд байдаг газар нутгаар явж сургаал номлолоо айлдаж байсан нь эдгээр хүмүүсийн монголоо гэх сэтгэлд нь ихээхэн дэм болсон гэж үзэж болно.

Ийнхүү Халимагт IX Богд заларсан цагаас эхлэн нэгэн зууны тэртээгээс тасраад байсан халимагийн бурхны шашны сүсэгтэн олон дахин Энэтхэг, Төвдийг зорих нь жил бүр нэмэгдсээр байна. Ийнхүү Төвдийг зорих халимагуудын хувьд Далай багш болон бурхны шашны сүм хийдүүдэд мөргөхөөс гадна IX-р Богдод зорих болсон нь «... түүнийг зорин очих халимаг сүсэгтнүүдээс гадна, түүнд шавь орсон халимагуудын тоо ч гэсэн нэлээд олон»⁹ дэргэдийнх нь шавийн ярианаас харагдаж байна.

⁶ Дилов хутагтын хойт дүр Тэло Тулку ринбүүчитай Улаанбаатар хотод 2014.4.20-ний өдөр хийсэн ярилцлага [Батсайхан 2015: 339–343].

⁷ Богдын хүү Чоймпал-Ёндонтой хийсэн ярилцлага [Батсайхан 2015: 274–291].

⁸ Дилов хутагтын хойт дүр Тэло Тулку Ринбүүчи 2014.4.20-нд Улаанаатарт хийсэн ярилцлага [Батсайхан 2015: 339–343].

⁹ Богдын дэргэдийн шавь Ч. Гүнзээ: бурхны шашны эзэн нь заларсан болохоор бүх юм сайхан амирласан болов уу гэж боддог. 2014.4.9-нд хийсэн ярилцлага [Батсайхан 2015: 490–491].



Зураг 14. Одсэр ринбүүчи, хамба лам Чойжамч, халимагийн Дилэв хутагт нар
(=Дилов хутагтын хойт дүр Тэло Тулку Ринбүүчи)
Сандон ринбүүчид бараалхаж буй нь [Батсайхан 2015: 686].
[Fig. 14. Odser Rinpoche, Khambo Lama Choijamts and Telo Tulku Rinpoche
(reincarnation of Dilova Khutuktu) visiting Sandon Rinpoche]



Зураг 15. Монголоос тодорсон хувилгаад хамба лам нарын хамт
[Батсайхан 2015: 466–688].
[Fig. 15. Khambo Lamas and Monks]

Баруун гар талаас: Жалханз хутагт, Сарайдорж номун хан, Гүшири хувилгаан, Ноён хутагт, Дандар (Тайвань хүн), Жонон ханчин, Одсэр ринбүүчи, Дилов ринбүүчи, Д. Чойжамц хамба лам, Н. Нанзаддорж дэд хамба лам, Дамцагдорж хувилгаан, Манзушир хутагт, Ламын гэгээн, Бамбар эрдэнэ, Сэнгэ гэвшийн хойт дүр (төвд лам) нар

Эдгээрээс гадна халимагийн эгэл жирийн лам хуврагууд ч гэсэн IX-р Богдтой тодорхой хэмжээгээр харилцаж, түүнтэй холбогдох үйл ажиллагаанд нь оролцож байжээ. Тухайлбал:

2009 оны үхэр сарын шинийн 15-нд Энэтхэгийн Дарамсала хотод тухайн үед Гоман дацанд суралцаж байсан монгол лам Батнасан, Ундраа нарын санаачилгаар Монгол улс дахь Жавзандамба төв болон Халимагийн бурхны шашны тэргүүн Дилов хутагт нар ивээн тэтгэж IX Богд Жавзандамба хутагтад бат оршил өргөсөн [Батсайхан 2015: 104]. Энэхүү ёслолд Гоман дацанд суралцаж байсан монгол лам нараас гадна Сэра жэ дацанд суралцаж байсан монгол, буриад, тува, халимаг, өвөр монгол лам нар оролцсон байна.

Мөн 2012.3.10 буюу хаврын тэргүүн сарын шинийн 17-ны өдөр Улаанбаатарт Богдын өргөөнд монголын томоохон хутагт хувилгаад болох Ламын гэгээн, Сансрайдорж номун хан, Жалханз хутагт, Гачэн лам нар Жонжүг, Жамбал цанжод хурахад Орос, Буриад, Халимаг, Тува шавь нар нь лүйжин тавьсан байна [Батсайхан 2015: 248].

2012 онд IX-р Богд нас барсан явдалд халимагийн ард түмэн маш ихээр харамсаж байсан бөгөөд халимагийн сүсэгтэн олныг төлөөлөн тухайн үеийн Халимагийн Ерөнхийлөгч Алексей Маратович Орлов [Орлов 2012] «Шажин лам Тэло Тулку Ренбүүчи нар албан ёсоор эмгэнэл илэрхийлж [Обращение Ело Ринпоче 2012], Халимагийн бурхны шашны төв «Бурхан багшийн алтан сүм»-д *гурван өдрийн гишүүдал зарласан* байдаг [Обращение Ело Ринпоче 2012]. Мөн тус сүмээс нэг жилийн дараа буюу 2013.3.1-ний өдөр *IX Богдын хойдын буяны үйлд зориулсан ном хурж, буяны ажил хийж, түүний Халимагт хийж байсан айлчлалуудын талаар сүсэгтэн олонд зориулсан гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж* байв [В главном храме ... 2013].

IX-р Богдын Халимагт удаа дараа залран сүсэгтэн олонд ном айлдсан явдал, түүний нөлөө, ач холбогдлыг Халимагийн Ерөнхийлөгч А. М. Орлов «... 1990-ээд оны хүнд хэцүү цаг үед Халимагт бурхны шашин дэлгэрэхэд ихээхэн түлхэц үзүүлсэн» [Орлов 2012] хэмээн үнэлсэнтэй өчүүхэн миний бие санал нэгтэй байна.

Дүгнэлт

IX-р Богд нь Халимагт нийтдээ 6 удаа заларсан бөгөөд тэрээр халимагийн сүсэгтэн олондоо зориулан бурхны шашны томоохон ном болох Тэнгэрийн ван болон бусад ном сургаалаа айлдаж байв. Түүний ийнхүү халимагт хэдэнтэй айлчлахад Халимагийн төрийн тэргүүн К. Н. Илюмжинов, шашны тэргүүн Дилов хутагт нар ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна. IX Богд нь Халимагт хэдэнтэй айлчилсан явдал Халимагийн бурхны шашны дэлгэрэлтэнд ихээхэн нөлөө үзүүлснээр зогсохгүй халимагийн сүсэгтнүүдийн оюун санааны удирдагчийн нэг болсон юм. Ингэснээр Халимагийн сүсэгтнүүд IX-р Богдыг зорин очих нь ихэссэн юм. IX-р Богдыг жанч халах үед Халимагийн төрийн тэргүүн А. М. Орлов, Шажин лам Дилов хутагт нар албан ёсоор эмгэнэл илэрхийлэн халимагийн бурхан шашны төвд хойтын буяны үйлийг нь хийж байсан зэрэг нь түүнийг Халимагт ихээхэн нэр хүндтэй байсныг харуулж байна.

IX-р Богдын дэргэдийн хүмүүс болон шавь нарынх нь ярианд 1997, 2000, 2009 онуудад Халимагт заларсан гэх ч яг тухайн үйл явдлынх нь тухай баримт мэдээ олдохгүй байна. Харин энэ үед ОХУ-ын бусад буддын шашинт газрууд болох Тува, Буриадад заларч байжээ. Эндээс үзвэл дээрх хүмүүсийг андуурсан

гэж үзэж болохоор байна. Мөн 1999 онд Халимагаас Монголд ирээд буцаад Халимаг, Буриад, Москва зэрэг газраар 9 сар явсан гэх мэдээ байгаа ч Халимагт дахин очсон тухай баримт байхгүй байна.

Ном зүй

- Айлдвар сургаал 2009 — Айлдвар сургаал. Эрхлэн хэвлүүлсэн. Гандантэгчлэн хийд. Улаанбаатар, 2009. 68 х.
- Батсайхан 2015 — Батсайхан О. IX Богд Жавзандамба хутагт: Амьдрал ба цаг хугацаа. Улаанбаатар: Мөнхийн Үсэг, 2015. 766 х.
- В главном храме ... 2013 — В главном храме Калмыкии молились о скорейшем перерождении защитника и покровителя монголоязычных народов Богдо-гегяна. Фоторепортаж. [электронный ресурс] // URL: <http://khurul.ru/2013/03/v-glavnom-hrame-kalmykii-molilis-o-skorejschem-pererozhdenii-zashhitnika-i-pokrovitelya-mongoloyazychnyx-narodov-bogdo-gegyanafotoreportazh/> (дата обращения 02.03.2017).
- В Калмыкии ... 2007 — В Калмыкии проходит визит духовного лидера монголоязычных народов. Видеорепортаж. [электронный ресурс] // URL: http://savetibet.ru/2007/10/08/bogdo_gegen_in_kalmykia.html (дата обращения 02.03.2015).
- Визит 2007 — Визит Его Преосвященства Богдо Гегяна URL: http://savetibet.ru/2007/10/01/bogdo_gegen_in_russia.html?fbclid=IwAR08seBAdRx1SwvB9IP-x3EsE0eAlgnCJMilgADtefQXIPeyb4AHGCL8t4U (дата обращения 02.03.2015).
- Далай-лама и Калмыкия. Элиста: Калм кн. изд-во, 2002. 44 с.
- Его Преосвященство ... — Его Преосвященство Богдо-гегян в памяти калмыцких учеников. Лариса Бадмаева: Я вспоминаю Его Преосвященство как сильное божество, как защитника [электронный ресурс] // URL: <http://khurul.ru/2013/03/ego-preosvyashhenstvo-bogdo-gegyan-v-pamyati-kalmyckix-uchenikov/> (дата обращения 02.02.2014).
- История буддизма 2011 — История буддизма в СССР и Российской Федерации в 1985–1999 гг. Элиста: Министерство образования, культуры и науки Республики Калмыкия, 2011. 392 с.
- О приезде 2005 — О приезде Его Преосвященства Богдо-гегяна [электронный ресурс] // URL: <http://khurul.ru/2005/08/testpage-15/> (дата обращения 02.03.2015).
- Обращение Ело Ринпоче 2012 — Обращение Ело Ринпоче относительно ухода Его Святейшества Халха Джецуна Дамбы Богдо Гегена Ринпоче IX [электронный ресурс] // URL: <http://khurul.ru/2012/03/obrashhenie-elo-rinpoche-otnositelno-uxoda-ego-svyatejshestva-xalxa-dzhecuna-damby-bogdo-gegena-rinpoche-ix/> (дата обращения 02.03.2019).
- Орлов 2012 — Алексей Орлов направил соболезнования в связи с кончиной главы буддистов Монголии [электронный ресурс] // URL: <http://savetibet.ru/2012/03/01/bogdo-gegen-rinpoche.html> (дата обращения 02.03.2019).
- Программа визита 2005 — Программа визита Его Преосвященства Богдо-гегяна в Калмыкию с 5 по 11 августа 2005 года [электронный ресурс] // URL: <http://khurul.ru/2005/08/testpage-16/> (дата обращения 02.03.2019).
- Хальмг үнн 1999 — Хальмг үнн. 1999.6.30. тал. 1.
- Хальмг үнн 2003 — Хальмг үнн. 2003.9.30. тал. 2.

References

- Aleksey Orlov sent condolences over the passing of Mongolia's Buddhist spiritual leader. Available at: <http://savetibet.ru/2012/03/01/bogdo-gegen-rinpoche.html> (accessed: March 2, 2019). (In Russ.)

- Batsaikhan O. 9th Jebtsundamba Khutuktu: Life and Time. Ulaanbaatar: Myonkh useg, 2015. 766 p. (In Mong.)
- Dalai Lama and Kalmykia. Elista: Kalmyk Book Publ., 2002. 35 p. (In Russ.)
- His Holiness Bogd Gegeen in Kalmykia (August 5–11, 2005): Visit Schedule. Available at: <http://khurul.ru/2005/08/testpage-16/> (accessed: March 2, 2019). (In Russ.)
- His Holiness Bogd Gegeen. Memoirs of Kalmyk disciples. Larisa Badmaeva: 'I recall him as a powerful protector deity'. Available at: <http://khurul.ru/2013/03/ego-preosvyashhenstvo-bogdo-gegyan-v-pamyati-kalmyckix-uchenikov/> (accessed: February 2, 2014). (In Russ.)
- Kalmykia welcomes the spiritual leader of Mongolic peoples. Video report. Available at: http://savetibet.ru/2007/10/08/bogdo_gegen_in_kalmykia.html (accessed: March 2, 2015). (In Russ.)
- Khal'mg ünn.* 1999, June 30. P. 1. (In Kalm.)
- Khal'mg ünn.* 2003, September 30. P. 2. (In Kalm.)
- Monks of Kalmykia's central Buddhist temple held a public prayer for the soonest rebirth of Bogd Gegeen, protector and spiritual guide to Mongolic peoples. Photographic report. Available at: <http://khurul.ru/2013/03/v-glavnom-xrame-kalmykii-molilis-ostskorejshe-pererozhdenii-zashhitnika-i-pokrovitelya-mongoloyazychnyx-narodov-bogdo-gegyanafotoreportazh/> (accessed: March 2, 2017). (In Russ.)
- History of Buddhism in the USSR and Russian Federation: 1985-1999. Abaev N. V., Bakaeva E. P. et al. Elista: Kalmykia Ministry of Education, Culture and Science, 2011. 392 p. (In Russ.)
- Report on the visit of His Holiness Bogd Gegeen. Available at: <http://khurul.ru/2005/08/testpage-15/> (accessed: March 2, 2015). (In Russ.)
- The Teaching and Precepts. Ulaanbaatar: Gandantegchinlen Monastery, 2009. 68 p. (In Mong.)
- Vizit of His Holiness Bogd Gegeen. Available at: http://savetibet.ru/2007/10/01/bogdo_gegen_in_russia.html?fbclid=IwAR08seBAdRx1SwvB9IP-x3EsE0eAlgnCJMilgADtefQXIPEyb4AHGCL8t4U
- Yelo Rinpoche. On the passing of His Holiness Khalkha Jebtsundamba Bogd Gegeen Rinpoche. Available at: <http://khurul.ru/2012/03/obrashhenie-elo-rinpoche-otnositelno-uxoda-ego-svyatejshestva-xalxa-dzhecuna-damby-bogdo-gegena-rinpoche-ix/> (accessed: March 2, 2019). (In Russ.)